



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/70

Улаанбаатар хот

Эд хөрөнгийн тооллого хийх комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь заалт, 71 дүгээр зүйлийн 71.7 дахь заалт, 72 дугаар зүйлийн 72.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт, 12.2.1 дэх заалт, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын 2022 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгө, материалын тооллого хийх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

Гишүүд: Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Мэдээлэл технологи, цахим хөгжил хариуцсан ажилтан

Архив, бичиг хэргийн эрхлэгч

Нарийн бичгийн

дарга: Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд хариуцсан менежер

2. Эд хөрөнгийн тооллого хийх комиссын гишүүдийг мэргэжлийн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж, дүн мэдээг танилцуулан ажиллахыг комиссын дарга /Х.Содномдэмбэрэл/-д даалгасугай.



ДАРГА

Д.БАТСҮХ

1150500306